**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 02 өдөр Дугаар Б/03 Чингис хот

Б.Цэцэгсайханыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" 275 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 89 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Баатарын Цэцэгсайханыг Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын бодлого хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд 2023 оны 0 дүгээр сарын 02-оос эхлэн томилсугай.

2.Б.Цэцэгсайханы үндсэн цалинг ТЗ-6-1 шатлалаар тогтоон, 690,018 (зургаан зуун ерэн мянга арван найм) төгрөгөөр тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3.Боловсролын бодлого хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Цэцэгсайханд үүрэг болгосугай.

ДАРГА Ж.ГАНБААТАР